



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бат-Өлзий сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2022/41/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Арвайхээр

2022 он

Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: О.Батжаргал


Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com

Аудитор: Б.Авидцэрэн

Утас: 70323833 Цахим хаяг: AvidtserenB@audit.gov.mn



1. Аудитын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

102171 Арсланхэр, Өвөрхангай аймаг
Утас/факс: 75701 7032 3253
E-mail: ovorkhangai@audit.gov.mn

2022.02.11 № 133
Төрийн _____ -ийн № _____ -т

БАТ-ӨЛЗИЙ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГА Ч.ДАЛАЙСҮРЭН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бат-Өлзий сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бат-Өлзий сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлэн гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Бат-Өлзий сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	7933443.00	10543253.00
33	АВЛАГА	60090.00	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	60090.00	0.00
33102	НДШ-ийн авлага	60090.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	0.00	2669900.00
35400	Хангамжийн материал	0.00	2669900.00
35410	Бичиг хэргийн материал	150000.00	150000.00
35420	Аж ахуйн материал	23200.00	23200.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	154000.00
35450	Барилгын засварын материал	0.00	966900.00
35470	Бусад хангамжийн материал	7700153.00	9249153.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	1278199620.32	1269392540.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	0.00	-8807079.69
39200	Биет хөрөнгө	0.00	-8807079.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	1240000000.00	1240000000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	-34485658.31	-55152324.95
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	49569640.00	50187185.01
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	-26310071.54	-18520219.68
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59068743.00	53533043.50
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	-24324057.83	-15812668.25
39217	Номын фонд	12819025.00	13295525.00
39300	Биет бус хөрөнгө	0.00	5462000.00
39301	Програм хангамж	0.00	3600000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1862000.00	1862000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	1286133063.32	1279935793.63
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	0.00	648937.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	648937.00
41300	Өглөг	0.00	648937.00
41360	Бусад өглөг	0.00	648937.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	648937.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	1286133063.32	1279286856.63
51	Засгийн газрын хувь оролцоо	1286133063.32	1279286856.63
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	60950286.00	60950286.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1225182777.32	1218336570.63
51210	Өмнөх үеийн үр дүн	1225182777.32	1225182777.32
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-6846206.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	1286133063.32	1279935793.63

Бат-Өлзий сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	442,132,979.00	176,218,548.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	295,954,179.00	15,199,048.51
1200	Нийтлэг татварын бус орлого	295,954,179.00	15,199,048.51
12001	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	15,199,048.51
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	295,954,179.00	14,899,048.51
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		300,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	146,178,800.00	161,019,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	146,178,800.00	161,019,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	146,178,800.00	161,019,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	172,131,907.92	181,904,755.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	172,131,907.92	181,904,755.12
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	168,730,740.78	175,625,651.56
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	68,778,188.60	67,305,573.00
210101	Үндсэн цалин	66,778,188.60	65,305,573.00
210105	Гэрээт ажлын цалин	2,000,000.00	2,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,605,411.26	8,742,093.44
210201	Тэтгэврийн даатгал	5,860,462.84	6,132,913.89
210202	Тэтгэмжийн даатгал	689,466.39	652,453.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	551,572.90	521,964.09
210204	Ажилгүйдлийн даатгал	134,979.35	129,852.71
210205	Эрүүл мэндийн даатгал	1,368,929.78	1,304,908.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,245,833.00	60,483,537.00
210301	Гэрэл, цахилгаан	-	588,778.00
210302	Түлш, халаалт	54,145,833.00	59,869,759.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	25,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,881,500.00	4,492,220.00
210401	Бичиг хэрэг	516,040.00	938,650.00
210402	Тээвэр, шатахуун	1,621,900.00	955,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,033,960.00	712,120.00
210404	Ном, хэвлэл	-	15,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	709,600.00	1,870,600.00
2105	Нормативт зардал	135,000.00	110,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	135,000.00	110,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	334,100.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	334,100.00
2107	Томиллот, зочны зардал	358,000.00	472,000.00
210702	Дотоод албан томиллот	358,000.00	472,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	462,000.00	400,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	462,000.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,264,807.92	33,286,128.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	290,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	30,964,807.92	32,996,128.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,401,167.14	6,279,103.56
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,251,167.14	6,134,103.56
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,251,167.14	6,134,103.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	150,000.00	145,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	150,000.00	145,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	1,160,000.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=II)	270,001,071.08	(5,686,206.61)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	1,160,000.08
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	1,160,000.08
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,160,000.08
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	270,001,071.08	(6,846,206.69)

Бат-Өлзий сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,950,286.00	1,225,182,777.32	1,286,133,063.32
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	60,950,286.00	1,225,182,777.32	1,286,133,063.32
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00
7	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			0.00
8	Тайлант үеийн үр дүн		-6,846,206.69	-6,846,206.69
9	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,950,286.00	1,218,336,570.63	1,279,286,856.63

Бат-Өлзий сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	146,178,800.00	161,019,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	146,178,800.00	161,019,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	146,178,800.00	161,019,500.00
132001	байгууллага/	146,178,800.00	161,019,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	142,510,100.00	150,569,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	142,510,100.00	150,569,500.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	139,108,932.86	144,290,396.44
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	68,778,188.60	67,245,483.00
210101	Үндсэн цалин	66,778,188.60	65,245,483.00
210105	Гэрээт ажлын цалин	2,000,000.00	2,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,605,411.26	8,742,093.44
210201	Тэтгэврийн даатгал	5,860,462.84	6,132,913.89
210202	Тэтгэмжийн даатгал	689,466.39	652,453.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	551,572.90	521,964.09
210204	Ажилгүйдлийн даатгал	134,979.35	129,852.71
210205	Эрүүл мэндийн даатгал	1,368,929.78	1,304,908.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,245,833.00	59,834,600.00
210301	Гэрэл, цахилгаан	-	588,778.00
210302	Түлш, халаалт	54,145,833.00	59,220,822.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	25,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,001,500.00	4,492,220.00
210401	Бичиг хэрэг	650,000.00	938,650.00
210402	Тээвэр, шатахуун	1,621,900.00	955,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,050,000.00	712,120.00
210404	Ном, хэвлэл	-	15,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	679,600.00	1,870,600.00
2105	Нормативт зардал	120,000.00	110,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	120,000.00	110,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,455,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,455,000.00
2107	Томилолт, зочны зардал	358,000.00	472,000.00
210702	Дотоод албан томилолт	358,000.00	472,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,700,000.00	1,649,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,700,000.00	1,649,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	290,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00	290,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,401,167.14	6,279,103.56
2134	санхүүжилт	3,251,167.14	6,134,103.56
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,251,167.14	6,134,103.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	150,000.00	145,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	150,000.00	145,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	3,668,700.00	10,450,000.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,668,700.00	10,450,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,668,700.00	10,450,000.00
223	БУСАД ХӨРӨНГӨ	3,668,700.00	10,450,000.00
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,668,700.00	10,450,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(3,668,700.00)	(10,450,000.00)
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	-
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	-	-
14	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

Бат-Өлзий сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
11000 - Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл		-	-
71702 - Соёл урлаг		161,019,500.00	161,019,500.00
80101 - Үндсэн үйл ажиллагааны зардал		159,225,000.00	159,225,000.00
12	Татварын бус орлого	159,225,000.00	159,225,000.00
122	Тусламж, санхүүжилтийн орлого	159,225,000.00	159,225,000.00
122005	Төсвөөс санхүүжих	159,225,000.00	159,225,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	159,225,000.00	153,091,396.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	159,225,000.00	153,091,396.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	159,225,000.00	153,091,396.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	72,036,800.00	67,245,483.00
210101	Үндсэн цалин	70,036,800.00	65,245,483.00
210105	Гэрээт ажлын хөлс	2,000,000.00	2,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,725,000.00	8,742,093.44
210201	Тэтгэврийн даатгал	6,843,500.00	6,132,913.89
210202	Тэтгэмжийн даатгал	720,400.00	652,453.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	576,300.00	521,964.09
210204	Ажилгүйдлийн даатгал	144,100.00	129,852.71
210205	Эрүүл мэндийн даатгал	1,440,700.00	1,304,908.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,834,600.00	59,834,600.00
210301	Гэрэл, цахилгаан	1,173,800.00	588,778.00
210302	Түлш, халаалт	58,563,800.00	59,220,822.00
210303	Цэвэр, бохир ус	97,000.00	25,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,942,600.00	4,942,220.00
210401	Бичиг хэрэг	1,033,200.00	938,650.00
210402	Тээвэр, шатахуун	897,300.00	955,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,018,500.00	712,120.00
210404	Ном, хэвлэл	485,000.00	465,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,508,600.00	1,870,600.00
2105	Нормативт зардал	116,400.00	110,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	116,400.00	110,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,455,000.00	11,455,000.00
210601	Багаж, техник хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	1,455,000.00	1,455,000.00
2107	Томилолт, зочны зардал	485,000.00	472,000.00
210702	Дотоод албан томиллолт	485,000.00	472,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	338,600.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	314,300.00	-
210807	Газрын төлбөр	24,300.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	291,000.00	290,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	291,000.00	290,000.00
80214 - Уран бүтээл хийлгэх		1,649,000.00	1,649,000.00
12	Татварын бус орлого	1,649,000.00	1,649,000.00
122	Тусламж, санхүүжилтийн орлого	1,649,000.00	1,649,000.00
122005	Төсвөөс санхүүжих	1,649,000.00	1,649,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,649,000.00	1,649,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,649,000.00	1,649,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,649,000.00	1,649,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	1,649,000.00	1,649,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,649,000.00	1,649,000.00
80802 - Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг		145,500.00	145,500.00
12	Татварын бус орлого	145,500.00	145,500.00
122	Тусламж, санхүүжилтийн орлого	145,500.00	145,500.00
122005	Төсвөөс санхүүжих	145,500.00	145,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	145,500.00	145,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	145,500.00	145,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	145,500.00	145,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	145,500.00	145,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	145,500.00	145,000.00
12000 - Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бат-Өлзий сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б.Авидцэрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Аймгийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бат-Өлзий сумын соёлын төв нь иргэдийн авьяас билгийг нээн хөгжүүлэх, түүх, соёлоо сурталчлах иргэдэд үзүүлэх соёл, иргэдэд үзүүлэх соёл, урлагийн үйлчилгээг чанартай хүртээмжтэй, тэдний санаа бодолд нийцүүлэн хэрэгцээг хангахуйц соёл мэдээллийн цогц орчинг бий болгох зорилго, чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага юм.

Тайлант хугацаанд тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын даргын тушаалаар батлагдсан журмын дагуу нэг ажилтан дотоод хяналт, шалгалтыг хавсран хариуцаж ажилладаг ба жилийн ажлын төлөвлөгөөг батлуулан ажилладаг байна.

Байгууллагын зохион байгуулалтын бүтцэд дотоод аудитын нэгж байхгүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бат-Өлзий сумын соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 181.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувь буюу 1.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө, бараа материалын болон авлага, өглөгийн тодруулгыг бэлтгэжээ:

- Үндсэн хөрөнгө оны эхнээс 8.8 сая төгрөгөөр буурсан байгаа нь хөрөнгө акталсан, ашиглах хугацаа дууссан хөрөнгөд дахин үнэлгээ хийсэнтэй холбоотой байна.
- Бараа материалын үлдэгдэл 2.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Өглөгийн дансанд оны эхэнд үлдэгдэлгүй байсан бол оны эцсээр төсөв хүрэлцээгүйгээс шалтгаалан халаалтын зардлын 0.6 сая төгрөгийн өглөг үүсч, тооцоо нийлсэн актаар баталгаажуулжээ.
- Урьд онд авлагын дансанд үлдэгдлээр тайлагнасан 0.06 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлтийн авлага барагдсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төслийг хуулийн хугацаанд бэлтгэж, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст нэгтгүүлж ирсэн байна. 2021 оны төсвийн төсөлд нийт зардлыг 160.1 сая төгрөгөөр төлөвлөсөн ба санхүүжилт 161.0 сая төгрөгөөр батлагджээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайланд оны төсөв 161.0 сая төгрөгөөр батлагдаж, санхүүжилт бүрэн хийгдсэн ба үүнээс 6.1 сая төгрөгийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлжээ. Оны нийт төсвийн гүйцэтгэл 154.9 сая төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Бат-Өлзий сумын соёлын төвд тайлант онд нэмэлт санхүүжилтийн гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Тайлант онд тус байгууллага нь төсвийн санхүүжилтийн 10.0 сая төгрөгөөр дуу, дүрс бичлэгийн студийн тоног төхөөрөмж, програм хангамж худалдан авсан байна. Энэ ажил гүйлгээний худалдан авах ажиллагаа болон хөрөнгө орлогод авсан асуудалд аудитор анхаарал хандуулсан бөгөөд тухайн үндсэн хөрөнгийн ангилалд залруулга хийлгэсэн болно.

Газар эзэмших эрх болон номын фондын хөрөнгийн ашиглах хугацааны бүртгэл, номыг нэр төрлөөр бүртгээгүй алдааг залруулахаар зөвлөмж өгснийг дор дэлгэрэнгүй дурьдах

болно. Үүнээс бусад эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэхэд алдаа зөрчил илрээгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Бат-Өлзий сумын соёлын төв нь шилэн дансны цахим хуудсанд нийт 150 мэдээлэл байршуулахаас 145 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг байршуулах хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгасан зүйлсийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэсэн болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах албан шаардлага өгөгдсөнийг биелүүлж, биелэлтийг албанбичгээр ирүүлжээ.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулахаар онцлох асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21.6 сая төгрөгийн алдаа илэрсэн.

4.1 Залруулсан алдаа

Тайлант онд худалдан авсан 3 програмыг тоног төхөөрөмжийн дансанд бүртгэснийг залруулж, биет бус хөрөнгийн програм хангамж дансанд тусгасан.

4.2 Төлбөрийн акт

Акт тавигдаагүй.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага бичигдээгүй.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааны бүртгэлийн асуудал

1.1. Илрүүлэлт:

Газар эзэмших эрх, номын фонд дансны нийт 15.2 сая төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг 0 жилээр тооцож санхүүгийн програмд тусгасан.

1.2. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн бүртгэлд газар эзэмших эрх, номын фонд дансдын хөрөнгийн ашиглах хугацааг залруулан бүртгэх.

2. Үндсэн хөрөнгийн бүртгэлийн асуудал

2.1. Илрүүлэлт:

Номын фондын 2.8 сая төгрөгийн хөрөнгийг бөөн дүнгээр бүртгэсэн тул тоо ширхэг, нэгж үнэ нь тодорхойгүй байгаагаас тооллогод хамрагдсан эсэх, хөрөнгө бодитоор оршин буй эсэх нь тодорхойгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн номын фонд дансанд бөөн дүнгээр бүртгэлтэй 2.8 сая төгрөгийн хөрөнгийг санхүүгийн бүртгэлд нэр төрлөөр нэгбүрчлэн тусгаж, тооллогыг чанартай гүйцэтгэж байх, эдгээр хөрөнгийн чанар байдалд дүгнэлт хийх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Бат-Өлзий сумын соёлын төв	3	21.6	1	3.6	0	0	0	0	2	18.0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Д.ГАНСҮХ

Б.АВИДЦЭРЭН